

Монголын хүн амын нас баралтын түвшний хандлага, түүнийг хөгжиж буй орнуудын түвшинтэй харьцуулах нь

Ц. Болормаа

Монгол Улсын Их Сургууль

Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвий багш

Нас баралт нь хүний нөхөн үржихүйн эсрэг талын үзэгдэл юм. Нас баралтын түвшин нь тухайн хүн амын нас, хүйсийн бүтэц, арьс өнгө, ажил эрхлэлтийн байдал болон нийгмийн тодорхой анги бүлэг гэх мэт олон төрлийн хүчин зүйлээс шалтгаалдаг. Түүнчлэн хүн амын амьжиргааны түвшин, эрүүл ахуйн нөхцөл байдал ч нас баралтын түвшинд нөлөөлдөг.


Энэ зуунд гарсан хүн ам зүйн томоохон өөрчлөлтийн нэг нь хүн амын нас баралтын түвшин мэдэгдэхүйц буурсан явдал юм. Нас баралтын түвшин чиг хандлагыг аваад үзсэн ч хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын аль алинд нь буурч байгаа бөгөөд хөгжингүй орнуудын хувьд бууралтын тогтвортой үедээ аль хэдийн хүрсэн байна. Япон, Швед, Швейцари, Норвеги зэрэг орнууд нь дэлхийд нас баралтын түвшингээрээ харьцангуй багатай орнуудын тоонд ордог ба хүн ам нь ч дэлхийн хүн амын тоонд маш бага хувийг эзэлдэг. Зарим хөгжиж буй орнуудын нас баралтын түвшин зарим нэг хөгжингүй орнуудынхаас ч доогуур байгаа юм. /Коста-Рика, Куба, Панам, Шриланка, Мавритан . . . / Гэвч энэхүү нас баралтын бууралт нь эдийн засгийн хөгжилтэй огт холбоогүй бөгөөд харин эрүүл мэндийг их хэмжээгээр импортлох болсонтой холбоотой.

XX зууны эхэн үед Монголд шинээр төрсөн 2 хүүхэд бүрийн нэг нь ойндoo хүрэлгүй эндэж, амаржсан эхийн 13.2 хувь нь нас барж, хүн амын тоо ч жил бүр буурсаар байлаа. Тэр үед харанхуй бүдүүлэг хоцрогдсон байсны зэрэгцээ ард түмний аж байдал, эрүүл мэндийг хамгаалах талаар ямар ч арга хэмжээ авдаггүй байв. Хөгжиж буй бусад улс орнуудын нэг адил 1950, 1960-аад онуудад Монголд нас баралт харьцангуй их буурсан. Тухайлбал, 1940-өөд оны үед нас баралтын ерөнхий коэффициент 1000 хүн ам тутамд 30 илүү байсан бол 1960-аад оны эцэст энэ нь 12 болж буурчээ. 1960-аад оны сүүлчээс нас баралтын бууралт тогтворжиж эхэлсэн. Сүүлийн 20 гаруй жилийн дотор нас баралтын ерөнхий коэффициент 31.8 хувиар, нялхасын нас баралт 20.4 хувиар буурчээ. Монголын хүн амын нийт нас баралт харьцангуй буурсан нь хүн амын аж байдал, соёлын түвшин дээшилсэн, хүүхдийг урьдчилан сэргийлэх тарилгад бүрэн хамруулах болсноор хурц халдварт өвчнүүдийн өвчлөл, түүнээс үүдэн гарах нас баралтыг эрс бууруулсан, эмнэлгийн үйлчилгээг хүн амд хүргэж чадсаны үр дүн юм. Хүснэгт 1-ээс үзвэл нас баралтын ерөнхий коэффициент 1970-1994 онуудад 12.3-7.3 болж ихээхэн буурчээ.

Монголын хүн амын нас баралтын түвшинг дэлхийн бүс нутгуудын болон зарим хөгжиж буй орнуудын түвшинтэй харьцуулсан байдлыг Зураг 1, Зураг 2-оос харж болно. Эндээс Монгол улсын хүн амын нас баралтын түвшнийг дэлхийн бусад орнуудтай харьцуулж үзвэл ихээхэн доогуур түвшинд байна гэж хэлж болохоор байна. Гэвч хүн амын нас баралтын түвшинг ойрын жилүүдэд мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах нөөц ихээхэн хомс байгаа юм. Энэ нь хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг дагалдаж хүн амын нас баралтын түвшин нэмэгдэх хандлага байгаатай холбоотой бөгөөд ийм нөхцөл байдалд Монголын хүн амын тооны цаашдын өсөлтийг хангах үндэс нь хүн амын төрөлтийн хэмжээ байх болно.


Зураг 1. НБЕК, бүс нутгаар

1990-1995 он



Зураг 2. НБЕК

1990-1995 он




Хүснэгт 1.

Нас баралтын ерөнхий коэффициент, 1969–1995

Он	Нас баралтын ерөнхий коэффициент
1969-1974	12.3
1974-1979	10.4
1979-1984	10.6
1984-1989	9.8
1990	8.5
1991	8.3
1992	8.4
1993	7.9
1994	7.3
1995	7.3


Ашигласан материал: "Монгол Улсын Эдийн Засаг, Нийгэм 1995 онд" УСГ.

Нас баралтын түвшинг бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад манай орных нэлээд бага байгаа боловч үүнийг Монголын хүн амын насны бүтэц "залуу", 65-аас дээш настай хүн ам нийт хүн амын дөнгөж 3–5 хувийг эзэлдэгээр тайлбарлаж болох бөгөөд аливаа хоёр орны нас баралтын түвшинг зэрэгцүүлэн судлах тохиолдолд насны бүтцийн заагийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.



Нас баралтын түвшнийг нас хүйсийн ялгавартай байдлаар нь аваад үзэхэд эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийн нас баралтаас илүү давамгай байгаа юм. Насны бүлгийн хувьд 0–4 настай нялхас, хүүхдийн нас баралт, 65-аас дээш насны хөгшчүүдийн нас баралт бусад насныг бодоход харьцангуй өндөр нас баралтын түвшинтэй байна. Ер нь ч ийм зүй тогтол дэлхийн бусад бүх оронд ажиглагддаг. Зураг

3, Зураг 4-өөс харахад 1969–1993 он хүртэлх сүүлийн 30 жилийн хугацаанд эрэгтэйчүүдийн нас баралт байнга эмэгтэйчүүдийнхээс илүү байсан нь харагдаж байна. Энэ нь эрэгтэй хүн эмэгтэйчүүдийг бодвол илүү их нас барах магадлал өндөртэй байдаг ба тэдний биологийн болон физиологийн үйл ажиллагаатай холбоотойгоор тайлбарлагдана.



Сүүлийн 20-иад жил нас баралтын түвшин буурсан хэдий ч эрч нь сул, тогтонги байна. Бусад орны нас баралтын түвшний бууралтын эрч нь сулраагүй байхад Монголынх яагаад суларч байна вэ гэдэгт хариулт өгөх хэрэгтэй болжээ. Үүний гол шалтгаан нь Монголын нийгэм эдийн засгийн хөгжил нь нас баралтын түвшинтэй зохицохгүй байгаатай холбоотой бөгөөд нийгэм эдийн засгийн түвшин нь хүн амын эрүүл амьдрах наад захын хэрэгцээг сайн хангаж чадахгүй байгаа явдал юм.

Мөн эрүүлийг хамгаалах системийн шугамаар хангагдаж байгаа эм, эмчилгээ нь зөвхөн эмчилгээний зориулалттай учир урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бараг байхгүйтэй адил болж хүн амдаа эрүүлийг хамгаалах систем тэр болгон хүрч чадаагүй болов уу гэдэг нь дээрх асуултын хариулт болж болох байна.

Нялхас, хүүхдийн эндэгдэл: Түүхийн хуудаснаас үзсэн ч Монгол улсад нялхас, хүүхдийн нас баралт, тэр дундаа нялхсын эндэгдэл нэлээд өндөр түвшинтэй байсан бөгөөд сүүлийн хэдэн жилийн байдлаас харахад буурах хандлагатай байна. Гэвч Монголын хувьд нялхсын нас баралтын бууралт маш удаан, өндөр түвшинд хэвээр байгаа гэж хэлж бүрэн болох бөгөөд энэ нь нэлээд анхаарал татсан асуудлын нэг болжээ. Зөвхөн нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл ч биш, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл харьцангуй өндөр байсаар байна. 1991 оны байдлаар нийт нас барагчдын 35.6 хувийг 0–4 насны хүүхэд эзэлж байна. 0–4 настай хүүхдүүдийн нас баралтын коэффициент 1955–1956 онд 39.4 байсан бол 1968–1969 онд 31.1, 1988–1989 он гэхэд 22.1 болж буурсан хэдий ч 1991 оны байдлаар 20.1 байгаа нь өндөр үзүүлэлт юм. Хүснэгт 2-оос харахад 1990 оноос хойшхи хугацаанд хүн амын нас баралт /Хүснэгт 1-ийг үз/ үүний дотор нялхсын нас баралт нилээд хэмжээгээр буурсан байдал ажиглагдаж байна. Энэ нь үнэн хэрэг дээрээ жилд төрсөн хүүхдийн тоо их хэмжээгээр цөөрснөөс болж ийм байдалтай байгаа болов уу гэж төсөөлөгдөж байгаа юм. Үүний

гол учир нь 0-4 насны хүүхдүүд хамгийн ихээр эндэгдэлд ордог хүн амын насны эмзэг бүлэг билээ.

Хүснэгт 2.

Нялхсын нас баралтын коэффициент, 1969-1994

Он	Нялхасын нас баралтын коэффициент
1969-1974	71.9
1974-1979	71.2
1979-1984	68.0
1984-1989	63.2
1990	64.4
1991	61.4
1992	57.3
1993	61.2
1994	44.7

Ашигласан материал: "Монгол Улсын Хүн Ам" УСГ, 1994 он.

Хүүхдийн нас баралтын шалтгааны хувьд 56.9 хувь нь амьсгалын эрхтэний өвчин, 11.6 хувь нь хоол боловсруулах эрхтэний болон суулгат өвчин, 10.5 хувь нь перинатал үеийн эмгэг, 14.6 хувь нь осол гэмтэл бусад шалтгаан, 6.4 хувь нь халдварт ба паразитийн өвчин эзэлж байна. Эндсэн 0-4 насны хүүхдийн дийлэнх хувь хөдөөд байна. Хүснэгт 3-д нялхасын нас баралтын түвшинг хамгийн их, хамгийн бага 5 аймаг, хотоор харууллаа.

Хүснэгт 3.

Нялхсын нас баралт, хамгийн их, хамгийн бага аймаг, хот, 1980-1993

(1000 амьд төрөлтөд ногдохоор)							
Нялхсын нас баралт хамгийн их 5 аймаг, хот							
1980		1985		1990		1993	
Дархан	109,9	Хэнтий	113,7	Баянхонгор	90,5	Өмнөговь	73,9
Архангай	106,3	Хөвсгөл	104,6	Дорнод	89,9	Архангай	73,1
Хөвсгөл	102,3	Баянхонгор	99,4	Улаанбаатар	75,6	Дорнод	73,0
Улаанбаатар	95,6	Дорнод	98,5	Хөвсгөл	74,2	Сэлэнгэ	72,6
Төв	94,9	Эрдэнэт	98,0	Архангай	71,3	Хөвсгөл	70,5
Нялхсын нас баралт хамгийн бага 5 аймаг, хот							
1980		1985		1990		1993	
Увс	34,5	Баян-Өлгий	49,2	Эрдэнэт	38,2	Төв	43,8
Сүхбаатар	35,0	Булган	51,7	Төв	44,7	Булган	47,5
Ховд	45,2	Дорноговь	52,8	Дорноговь	48,2	Дорноговь	47,6
Говь-Алтай	49,2	Дундговь	53,0	Баян-Өлгий	50,6	Дундговь	49,1
Дундговь	54,1	Ховд	53,6	Булган	51,9	Хэнтий	51,9

Ашигласан материал: "Монгол Улсын Хүн Ам", УСГ, 1994 он.

Дээрх хүснэгтээс үзэхэд төвийн бүсэд нялхсын нас баралт 1980-аад оны үед өндөр байснаа 1990-ээд он гэхэд нэлээд буурсан нь харагдаж байгаа боловч дээрх 4

оноор аваад үзэхэд Хөвсгөл аймаг нялхсын нас баралтаараа онцын ялгаа гараагүй байгаа нь мэдэгдэж байна. Нялхсын нас баралтын хамгийн их болон бага түвшинг аймаг хотоор харьцуулахад баруун бүсийн аймгууд маш бага түвшинтэй байгаа нь тэдний хоол хүнс, байгаль, цаг уурын болон эм эмнэлгийн үйл ажиллагаа ихээхэн өөр өөрийн онцлогтой болохыг харуулж байгаа юм. Говийн бүсийн аймгууд нялхсын нас баралт харьцангуй бага, тэд ихэвчлэн улсын дунджаас байнга бага байдаг гэдэг нь илт давуу харагдаж байна. Нялхсын нас баралтын энэ ялгаатай түвшин нь байгаль, цаг уур, бүсийн чанартай онцлог зүйлээс шалтгаалан бий болсон нь тодорхой юм.

Дэлхийн улс орнуудын нялхсын эндэгдлээс үзэхэд хот суурин газраа нялхсын эндэгдэл хөдөөг бодвол бага байдаг байхад Монголын хувьд хотдоо хөдөөг бодоход өндөр байна. Энэ нь нийгэм эдийн засгийн хөгжил нялхсын эндэгдэлд нөлөөлж чадаагүй гэдгийн нэг илрэл болж байна. Хот газар илүү хөгжил сайтай байдаг бөгөөд уламжлалт нөлөөлөл нь шулуун байдаг. Орчин үеийн эм эмчилгээг аливаа нэг улс орон нэвтрүүлэхдээ тухайн улсын уламжлал дээр тулгуурлан өөрийн онцлогт тохируулан нэвтрүүлэх хэрэгтэй гэдгийг ойшоож үзээгүйгээс ийм ялгавартай байдал үүсэж байж болох талтай. Мөн мэдээллийн хангалтгүй байдлаас бага зэрэг шалтгаалж магадгүй юм. Монгол улс нь нялхсын нас баралтын түвшингээрээ Латин Америкийн хөгжиж буй улс орнууд, Далайн орнуудтай бараг ойролцоо түвшинд явж байгаа юм. Хойд Африкийн улс орнуудтай дундаж наслалт ижил боловч нялхсын нас баралтын түвшин өндөр байдаг.

1994 онд ХАЗССТ-өөс явуулсан Хүн Ам Зүйн Судалгааны дүнгээс харахад ч нялхсын нас баралтын түвшин Монголын хувьд өндөр байгаа нь харагдлаа. Нялхсын нас баралтын түвшний ялгааг жилийн мэдээлэл, судалгааны мэдээлэл, тооллогын мэдээллээс шууд байдлаар тооцсон дүн зэргээр илэрхийлсэн бөгөөд 1975-1989 оны дунджаас үзэхэд нэг ой хүртэлх хугацаанд нас барах магадлал судалгааны дүнгээр бусад бүртгэлээс 30 промилиэр өндөр байна. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл хотод хөдөөгийн тал орчим хувьтай тэнцүү байна. Аймгийн төвийнх хотынхоос 19 хувиар өндөр байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ, хүмүүсийн амьдралын хэв маяг хотынхоос өөр байдагт оршино. Гэтэл сумын төвд нялхсын болон хүүхдийн эндэгдэл гайхалтай доогуур байгаа нь дээр өгсөн хариулт үнэн болохыг нотолж байна.

Эхчүүдийн боловсролын байдлаар авч үзэхэд боловсролгүй буюу бага боловсролтой эхчүүдийн 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн эндэгдэл нь дунд буюу дээд боловсролтой эхчүүдийнхээс 2 дахин өндөр байгаа юм. Эхийн боловсролын түвшинтэй хүүхдийн эндэгдлийн түвшин шууд хамааралтай. Ялангуяа дээд боловсролтой эхчүүдийн хүүхдүүдийн амьдрах магадлал илүү өндөр байна. Мөн залуу эхийн төрүүлсэн хүүхдийн эхний сардаа амьдрах магадлал 25 ба түүнээс дээш насны эхчүүдийн хүүхдүүдийн эхний сараас хойш нэг ой хүртлээ амьдрах магадлал ахиаг эхчүүдийнхээс бага байна. Энэ нь тэдний магадгүй хүүхдээ халамжлах арга барил эхчүүдийн наснаас шалтгаалсан байж болохыг үзүүлж байгаа юм.

Нялхас, хүүхдийн эндэгдэл төрөлтийн тоотой эерэг холбоотой байдаг. Төрөлтийн тоо ихсэх тутам нас барах магадлал ихэсдэг. Судалгааны дүнгээс үзэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2-оос доош жилийн хугацаанд төрсөн хүүхдийн дунд 4 буюу түүнээс дээш жилийн зайтай төрсөн хүүхдүүдийнхээс 2 дахин өндөр байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол улс нь буурай хөгжилтэй оронд ордог хэдий ч эдийн засгийн хувьд бусад буурай хөгжилтэй орнуудаас нэлээд өндөр, гэхдээ нялхсын нас баралт адил байдаг ба хүүхэд, нялхсын эндэгдэл нь зөвхөн эхийн эрүүл мэндийн байдал, жирэмслэлтээс нөлөөлөөд зогсохгүй нийгэм эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйл болох хөхөөр тэжээх практик, хоол тэжээл, хүүхдийн халамж, анхаарал, эрүүл мэндийн үйлчилгээ зэргээс хамаарч байдаг. Монголын хувьд бусад хөгжиж буй орнуудтай харьцуулж үзэхэд эмэгтэйчүүдийн

хөдөлмөрт оролцох байдал, бичиг үсэг мэдэлт нь тодорхой түвшинд хүрсэн ч нялхсын нас баралтын түвшинд нөлөөлж чадаагүй учир нялхсын эндэгдэл өндөр байгаа гэж таамаглаж байна.

Эхийн эндэгдэл: Манай оронд эхийн эндэгдлийн тухайд энэ үзүүлэлт буурахгүй байгаа явдал сэтгэл ихэд түгшээж байгаа юм. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд жирэмслэлттэй холбоотой эндсэн эхийн үзүүлэлт 100000 амьд төрөлтөд 120–220 ноогдож байна. 1976 оноос өмнөх жилүүдэд эхийн эндэгдэл хотын нөхцөлд улсын дунджаас их байлаа. Харин 1976 оноос хойш хотод эндэх эхийн эндэгдэл багасч хөдөөд эндэх эндэгдэл нэмэгдсэн. Ялангуяа сүүлийн жилүүдэд эндсэн эхчүүдийн 70 гаруй хувь нь сумын эмнэлэгт эсвэл хөдөө гэртээ эндэх болов. Энэ нь хөдөө сумдад ажиллаж буй ерөнхий мэргэжлийн эмч, эх баригч нарын эх барих эмэгтэйчүүдийн нэн шаардлагатай тусламж үзүүлэх чадавхи хангалтгүй, сумдад ажиллаж байсан эхчүүдийн амрах байрын тоо өмч хувьчлалын үеэр 5.5 дахин цөөрсөн, сум, баг, аймаг, хотын хооронд харилцаа холбоо, тээврийн бэрхшээл нэмэгдсэнээс хөдөө гэртээ төрөх эхийн тоо өссөн зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Дундаж наслалт: Дундаж наслалт бол таамаглах хэмжигдэхүүн бөгөөд хүн амын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох гол үзүүлэлт юм. Нас баралтын түвшний хандлагаас шалтгаалж хүн амын дундаж наслалт эрэгтэй эмэгтэйчүүдийн хувьд өөр өөр байдаг. Монголын хувьд 1984–1989 онд төрсөн эрэгтэйчүүд дунджаар 58.5 жил, эмэгтэйчүүд 62.4 жил амьдрана гэж тооцоолж байв. Монголын хүн амын нас баралтын түвшин доошилсонтой уялдаатайгаар дундаж наслалт ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн. Хүснэгт 4-ээс үзэхэд Монгол хүний дундаж наслалт сүүлийн 30 жилийн дотор ойролцоогоор 7.4 жилээр нэмэгдсэн ба одоо 62.5–64.1 болсон юм.

Монгол хүний дундаж наслалт, жилээр, 1956–1989

Хүснэгт 4.

Он	Эрэгтэй	Эмэгтэй
1956	55.1	56.7
1963	58.7	60.2
1969	60.5	61.9
1979	61.6	63.1
1989	62.5	64.1

Ашигласан материал: "Хүн ам ба хөгжил", ХАБХЯ, 1995

Буурай хөгжилтэй бүс нутагт 1985–1990 онд эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалт 58.2 жил байхад мөн үед хөгжингүй орнуудынх 73.9 жил байжээ. Дээрх байдлаас дүгнэлт хийхэд буурай хөгжилтэй орнуудад нялхасын эндэгдэл өндөр байгаагаас шалтгаалж дундаж наслалт доогуур байна.


Хөгжингүй орнуудын хувьд нялхсын нас баралт буурч байгаа бөгөөд нас баралтын түвшин нь удамшил юм уу биологийн талаас шалтгаална. Нялхсын эндэгдэл бараг доод шатандаа хүрч байгаа (зүй тогтлоороо) юм. Энэ тохиолдолд дундаж наслалтыг нэмэгдүүлэхийн тулд өндөр настанд анхаарлаа хандуулах нь чухал. Ялангуяа ахимаг насны хүмүүсийн өвчилдөг өвчнийг анагаах чадвал (цусны даралт, зүрхний шигдээс, биологи, физиологийн өвчнүүд) даруй хэдэн жилээр уртасгаж чадна.

Хөгжингүй орнуудад дундаж наслалт дунджаар 78 орчим жил байхад буурай хөгжилтэй орнуудад 60–65 орчим жил. Зарим буурай орнуудад тухайлбал, Афганистан 43, Бангладеш 53, Энэтхэг 50, Вьетнам 54 жил байгаа нь эдгээр улсуудад нялхсын нас баралт өндөр байгаагаар холбоотой. Хөгжингүй орны хувьд дундаж болон ахимаг насны хүмүүсийн эрүүл мэндэд нарийвчилбал, амьжиргааны арга

хэлбэрт нь анхаарахын бол даруй нас баралтыг бууруулж чадах болно. Харин буурай хөгжилтэй орны хувьд маш өөр юм. Учир нь нялхсын нас баралт маш өндөр учир тэд нийгэм эдийн засгийн бодлогыг юуны өмнө сайжруулах хэрэгтэй бөгөөд үүний үр дүнд хэдэн жилээр дундаж наслалтыг нэмэгдүүлэх болно.


1950–1955 онд Монголын хүн амын дундаж наслалт 42,2 жил байсан бол 2020–2025 онд 73 жил болж 30,8 жилээр нэмэгдэх тооцоо гарч байгаа бөгөөд энэхүү өөрчлөлт нь нялхсын нас баралтын түвшний бууралтын үр дүн юм. 2020–2025 он гэхэд нялхсын нас баралт одоогийнхоос бараг 3 дахин буурах хандлага ажиглагдаж байгаа нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, хүн амын эрүүл мэнд, хоол тэжээл, ялангуяа амьдралын хэв маяг, амьжиргааны түвшинд өөрчлөлт орно гэдгийг илэрхийлж байна. Зураг 5, Зураг 6–д Монголын хүн амын дундаж наслалт, нялхсын нас баралтын түвшинг 1950–2025 он хүртэлх байдлаар үзүүлсэн бөгөөд эндээс үзэхэд нялхсын нас баралтын түвшинг одоогийнхоос 3 дахин бууруулахад дундаж наслалт дөнгөж 10 орчим жилээр нэмэгдэх боломжтой байгаа нь харагдаж байна.

Монгол, Дундаж наслалт 1950–2025 он



Монгол, Нялхасын нас баралт

1950—2025 он



Ашигласан материал

"Монгол Улсын хүн ам" УСГ, 1994

"Монголын Хүн Ам Зүйн Судалгаа, 1994", ХАЗССТ, 1994

UNITED NATIONS "World Population Prospects", New- York, 1993

MPS-03, Population Dynamics "Mortality", IIPS